“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН
ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН ТАЙЛАН

2022 оны 12 дугаар сарын 07 — Багануур дүүрэг

| № | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Хэрэгжилт |
|---|---|---|
| | Нэг: Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх | |
| 1 | Ковид-19 цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан гарсан ЗГ, УОК, НОК, ДОК-оос гарсан тогтоол, шийдвэр, Засаг даргын захирамжийг мөрден хэрэгжилтийг тухай бүрт нь ханган дараах ажлыг зохион байгуулан ажилласан. Үүнд:<br>• Нийт ажилчдад халдвар хамгаалалтын дэглэмийг мөрдүүлж хүн хоорондын зайг барьж амны хаалтыг тогтмол зүүлгэж, өрөө тасалгааг халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулсан.Мөн ажлын байранд шаардлагатай дараах хэрэгслээр ханган ажиллаа<br>   | 100 |
| | Хоёр: Ажлын байрны аюулгүй ажиллагаа | |
| 2 | Албан тасалгааны ажилтны аюулгүй ажиллагааны зааварчилгааг нийт ажилтан албан хаагчдад тогтмол хүргэн мэдээлэл зөвлөгөө өгч ажиллаж байна. Үүнд:<br>• Ажил эхлэх, дуусах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа<br>• Ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа<br>• Уртасгагч залгууртай ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа<br>• Ачааг гараар өргөх, зөөх үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа<br>• Галын аюулгүй байдлыг хангах ажиллагааны зааварчилгаа<br>• Бусад | 100 |

| | | |
|---|---|---|
| 3 |      | |
| | Гурав: Ажил, мэргэжлийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх | |
| 3 | Ажлын байрны дасгал нь ажилтан, албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих, хөдөлмөрийн явцад бий болсон ядралыг сэргээх, ажлын чадварыг нэмэгдүүлэн улмаар хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх ач холбогдолтой. Иймд ажлын байрны дасгал хөдөлгөөнийг нийт ажилтан албан хаагчдад тогтмол цагт хийж хэвшүүлэх арга хэмжээ авч ажиллаж байна. Мөн хөдөлгөөний дутагдлаас сэргийлэн долоо хоног бүрийн 4 өдөр болгон МХС ТӨХК-ний биеийн тамирын зааланд нийт ажилтан албан хаагчдын ширээний теннис тогтмол тоглож байна.<br>  | 100 |
| | Дөрөв: Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй, журам, стандартын сургалт | |
| 4 | Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хууль тогтоомж журам стандартын чиглэлээр дотооддоо сургалт зохион байгуулж албан хаагч, ажилтнуудаа хамруулллаа.<br>Мөн гарын авлага, тараах материалыг бэлтгэж"Ажлын байрны эрүүл ахуй, албан хаагчдын ажлын онцлог эрүүл мэнд" зөвлөмж сургалтыг<br>4-р сарын 21 ны өдөр зохион байгуулж гарын авлага материалыг тараалаа. Ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуй, ая тухтай орчинг бүрдүүлэх тал дээр дотоод хяналтыг зохион байгууллаа. Цахилгаан, дулаан, гэрэлтүүлэг, | 100 |

| | | |
|---|---|---|
| | техник хэрэгсэл, ажлын эмх цэгц, ая тухтай орчин бүрдүүлэх зэрэг энгийн нөхцлийн дотоод хяналтыг зохион байгууллаа. Илэрсэн зөрчил үгүй. Гэрэлтүүлэг шатсан лампыг солилоо.<br>Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас жил бүрийн 04 дүгээр сарын 28-ны өдрийг "Ажлын байран дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэлхийн өдөр" болгон Олон улсын хэмжээд тэмдэглэж байхаар 2003 онд шийдвэрлэсэн байдаг тухай мэдээллийг хүргэж төлөвлөгөөний хэрэгжилтийг гарган Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэст хүргүүллээ | |
| | Тав: Ажлын байрны эрүүл ахуй | |
| 5 | Ажлын байрны эрүүл ахуй "Компютерийн зөв хэрэглээ зөвлөмж"-ийг, цахим хуудсанд байршуулах. болон нөлөөллийн зурагт хуудсууд, зөвлөмжийг хүргэж ажиллаа. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн 2021-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн үндсэн 5 зорилтын хүрээнд мэдээлэл танилцуулга хийж "хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн зэрэг соёл"-ыг хамтдаа төлөвшүүлье. нөлөөллийн зурагт хуудсыг байгууллагын цахим хуудас болон албан хаагчдын хувийн фейсбүүк хуудсаар дамжуулан сурталчлах нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж ажиллаа. Албан хаагчид ажилтны эрүүл мэнд болон нийгмийн асуудалд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах ажлын хүрээнд нүдний хараа шалгуулах болон бусад төрлийн үзлэг шинжилгээнд хамрагдах ажлыг зохион байгууллаа | 100 |
| | Жилийн эцсийн хэрэгжилт | 100% |

ХЯНАСАН:
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨТҮГ-ЫН ДАРГА Ч.ЭЛБЭГСАЙХАН

УЛААНБААТАР ХОТ
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГазар
УГД 014 8184062
2715 109064

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН
КЛАСТЕР ИНЖЕНЕР С.ЭНХБАТ